

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ГСА-2023/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг 2023 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК Захирал: Г.Энхмаа Утас: 77450279, Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс:976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

СҮМБЭР СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГ"-ИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ С.ТУЯАГЭРЭЛ ТАНАА

2023.02.27 № 34
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020130

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 хөтөлбөр зорилтын хүрээнд 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлтийг 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	62,162,349.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	19,280,068.98
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	19,280,068.98
31210	Төгрөг	0.00	19,280,068.98
31211	Төрийн сангийн харилцах	0.00	19,280,068.98
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	42,882,281.00
35100	Түүхий эд материал	0.00	66,000.00
35130	Эм боох материал	0.00	66,000.00
35400	Хангамжийн материал	0.00	42,816,281.00
35420	Аж ахуйн материал	0.00	908,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,350,000.00
35450	Барилгын засварын материал	0.00	1,385,000.00
35460	Хүнсний материал	0.00	3,234,392.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	35,938,889.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	1,139,973,222.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	1,139,973,222.29
39200	Биет хөрөнгө	0.00	1,032,145,722.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	1,135,779,256.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-129,228,101.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.00	49,301,757.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-35,501,183.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	31,639,946.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-19,845,953.75
39300	Биет бус хөрөнгө	0.00	107,827,500.00
39301	Програм хангамж	0.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,102,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	107,730,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	1,202,135,572.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,887,650.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	1,887,650.00
41300	Өглөг	0.00	1,887,650.00
41360	Бусад өглөг	0.00	1,887,650.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	1,887,650.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	1,200,247,922.27
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	1,200,247,922.27
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	109,467,290.73
51200	Хуримтлагдсан үр дүн	0.00	978,792,234.06
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	-221,516,094.21
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1,200,308,328.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	111,988,397.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	1,202,135,572.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант огноо: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,867,199,186.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,212,237,586.22
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,212,237,586.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	45,523,809.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	1,166,713,777.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	654,961,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	549,507,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	549,507,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	105,454,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	105,454,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	666,890,857.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	666,890,857.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	663,364,259.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	406,482,847.00
210101	Үндсэн цалин	0.00	406,482,847.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	50,286,000.52
210201	Тэтгэврийн даатгал	0.00	34,684,458.52
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	4,075,011.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,238,657.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	748,511.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	7,539,363.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	67,771,566.27
210301	Гэрэл, цахилгаан	0.00	7,955,473.87
210302	Түлш, халаалт	0.00	52,889,511.80
210303	Цэвэр, бохир ус	0.00	6,926,580.60
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	14,232,450.00
210401	Бичиг хэрэг	0.00	7,490,000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	2,485,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	4,256,950.00
2105	Нормативт зардал	0.00	75,952,684.64
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	883,009.64
210502	Хоол, хүнс	0.00	75,069,675.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	9,021,000.00
210604	Урсгал засвар	0.00	9,021,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	778,142.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	778,142.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	38,839,568.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,519,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	40,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	32,280,568.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3,526,598.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,526,598.73

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,526,598.73
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	1,200,308,328.27

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	109,467,290.73	111,988,397.48	1,007,662,496.10	1,229,118,184.31
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	1,007,662,496.10	1,229,118,184.31
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	-29,472,836.73	-29,472,836.73
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,200,308,328.27	1,200,308,328.27
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	109,467,290.73	111,988,397.48	978,792,234.06	1,200,247,922.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	654,858,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	654,858,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	549,404,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	549,404,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	105,454,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	105,454,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	635,578,031.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	635,578,031.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	632,051,432.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	407,303,353.52
210101	Үндсэн цалин	0.00	317,470,856.52
210102	Нэмэгдэл	0.00	64,689,769.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	9,210,000.00
210104	Урамшуулал	0.00	15,932,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	49,525,900.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	33,785,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	3,935,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,148,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	787,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	7,870,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	70,746,566.27
210301	Гэрэл, цахилгаан	0.00	7,955,473.87
210302	Түлш, халаалт	0.00	55,864,511.80
210303	Цэвэр, бохир ус	0.00	6,926,580.60
2105	Нормативт зардал	0.00	77,681,570.00
210502	Хоол, хүнс	0.00	77,681,570.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	6,980,000.00
210604	Урсгал засвар	0.00	6,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	938,142.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	938,142.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	18,875,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	11,345,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,530,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3,526,598.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,526,598.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,526,598.73
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	19,280,068.98
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	19,280,068.98
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	19,280,068.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	549,404,000.00	530,123,931.02	530,123,931.02	101,927,501.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,404,000.00	530,123,931.02	530,123,931.02	101,927,501.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,404,000.00	530,123,931.02	530,123,931.02	101,927,501.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,517,800.00	383,102,418.52	383,102,418.52	24,280,966.00
210101	Үндсэн цалин	328,968,300.00	295,255,768.52	295,255,768.52	22,295,119.00
210102	Нэмэгдэл	58,838,000.00	63,852,108.00	63,852,108.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	8,832,000.00	8,832,000.00	0.00
210104	Урамшуулал	5,711,500.00	15,162,542.00	15,162,542.00	1,985,847.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,525,900.00	49,525,900.00	49,525,900.00	-80,031.00
210201	Тэтгэврийн даатгал	33,785,300.00	33,785,300.00	33,785,300.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,935,100.00	3,935,100.00	3,935,100.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,148,100.00	3,148,100.00	3,148,100.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	787,100.00	787,100.00	787,100.00	.0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,870,300.00	7,870,300.00	7,870,300.00	-80,031.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	0.00	70,746,566.27
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	0.00	7,955,473.87
210302	Түлш, халаалт	0.00	0.00	0.00	55,864,511.80
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	0.00	6,926,580.60
2105	Нормативт зардал	86,226,400.00	77,681,570.00	77,681,570.00	0.00
210502	Хоол, хүнс	86,226,400.00	77,681,570.00	77,681,570.00	0.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	0.00	6,980,000.00
210604	Урсгал засвар	0.00	0.00	0.00	6,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,000.00	938,142.50	938,142.50	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	938,142.50	938,142.50	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,875,900.00	18,875,900.00	18,875,900.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,345,900.00	11,345,900.00	11,345,900.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,530,000.00	7,530,000.00	7,530,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	549,404,000.00	549,404,000.00	549,404,000.00	105,557,600.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	549,404,000.00	549,404,000.00	549,404,000.00	103,500.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	549,404,000.00	549,404,000.00	549,404,000.00	103,500.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	105,454,100.00
320001	Орон нутгийн төсвөөс	0.00	0.00	0.00	105,454,100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	19,280,068.98	0.00	19,280,068.98

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	105,454,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,454,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,454,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,454,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,454,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,454,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,927,501.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,200,935.00
210101	Үндсэн цалин	22,215,088.00
210102	Нэмэгдэл	837,661.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	378,000.00
210104	Урамшуулал	770,186.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,746,566.27
210301	Гэрэл, цахилгаан	7,955,473.87
210302	Түлш, халаалт	55,864,511.80
210303	Цэвэр, бохир ус	6,926,580.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,980,000.00
210604	Урсгал засвар	6,980,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,526,598.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,526,598.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,526,598.73

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд 397,847.5 мянган төгрөгийн ажил гүйлгээний 42 мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулаагүй, мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зарим гүйлгээг нийт дүнгээр багцалж оруулахдаа байршуулах шаардлагагүй үнийн дүнтэй 1,836.5 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна.	1	397,847.5			1	397,847.5		
Дүн	1	397,847.5			1	397,847.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд худалдан авалт нь 11,121.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Үүнд: цахим төлбөрийн системд и баримтыг 1,464.1 мянган төгрөгөөр илүү, 9,657.2 мянган төгрөгөөр дутуу оруулсан.	1	11,121.3			1	11,121.3		
Дүн	1	11,121.3			1	11,121.3		
Нийт дүн	2	408,968.8			2	408,968.8		



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар

54/10210473

Чойр

ГА 2023/32/НА-СГА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн хийсэн "Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг"-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд худалдан авалт нь 11,121.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Үүнд: цахим төлбөрийн системд и-баримтыг 1,464.1 мянган төгрөгөөр илүү, 9,657.2 мянган төгрөгөөр дутуу оруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг арилган биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

008040198

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг”-ийн эрхлэгч С.Туяагэрэл, нягтлан бодогч Б.Цэрэнбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН АХЛАХ АУДИТОР

Г.ЭНХМАА

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

421714745J
УСА0055 9019019



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 55/10210473

Чойр

ГСА-2023/32/НА-ЦГА-ДУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн хийсэн "Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг"-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 397,847.5 мянган төгрөгийн 42 мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар, 3.2.11-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

008040201

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг"-ийн эрхлэгч С.Туяагэрэл, нягтлан бодогч Б.Цэрэнбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН АХЛАХ АУДИТОР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ЭНХМАА

Б.САРАНТУЯА